

МОНГОЛ УЛСЫН ТҮҮХ, НИЙГЭМ СУДЛАЛЫН ТЭРГҮҮЛЭХ ЭРДЭМТЭН

*С.Дамдинсүрэн**

Өнөөдөр 80 насны сүүдэр зэрэгцсэн билигтэй сайн өдөртөө золгож буй академич доктор Бадамын Лхамсүрэн бол өөрийн амьдралын хагас зуу илүү жилийг Монголын шинжлэх ухааныг хөгжүүлэх үйлст зориулж, юуны өмнө Монголын төр, нийгэм, гадаад харилцааны асуудлуудыг шинжлэн судлахад ихээхэн хувь нэмэр оруулсан манай нэрт эрдэмтэн билээ.

Тэрбээр бүр долоон настай байхдаа бичгийн их хүн О.Жамьян гүнд шавь орж, монгол бичиг, тоо бодлого заалгаж байсан нь түүний ирээдүйн амьдралын гарааг чиглүүлж өгсөн хэрэг буй за.

Б.Лхамсүрэн гуай 1940-өөд оны сүүл, 50-иад оны эхэн үед Гадаад явдлын Яаманд ажиллах үеэсээ Монгол Улсын түүх, гадаад харилцааны асуудлыг ихэд сонирхон сурвалж материал цуглуулж, эрдэм шинжилгээний ажилд шимтэн татагдах болжээ. Иймээс эрдмийн мөр хөөж ЗХУ-д суралцах хүсэлтээ Ю.Цэдэнбалд илэрхийлсний дагуу түүнээс дэмжлэг авч Москва дахь Нийгмийн ухааны академийн аспирантурт шинэ түүхийн мэргэжлээр элсэн орсон тухайгаа “Арван зургадугаар жаран мину” /УБ, 2003 он/ дурсамж номдоо өгүүлжээ.

Тус Академид дөрвөн жил суралцаад “БНМАУ-ын гадаад бодлого ба дэлхийн хоёрдугаар дайны дараа түүний гадаад харилцаа өргөжсөн нь /1945-1957/” гэсэн сэдвээр 1958 онд түүхийн ухааны дэд эрдэмтний зэрэг амжилттай хамгаалжээ. Энэхүү диссертаци нь Монголын түүхэнд Монголын гадаад харилцааны хөгжилтийг тусгайлан авч үзсэн анхны эрдэм шинжилгээний бүтээл болсон бөгөөд тухайн үеийн олон улсын байдалд нийцүүлэн БНМАУ-ын гадаад бодлогын ерөнхий чиг хандлагыг тодорхойлон дүгнэснээрээ онол, практикийн ач холбогдолтой болсон юм. Түүний эл зохиолоос Монголын гадаад бодлогын биеэ даасан байдал, идэвхтэй үйл ажиллагааг нотлон харуулахад онцлон анхаарч байсныг харж болно. Энэ талаар Б.Лхамсүрэн гуай өөрийн дурсамждаа: Гэвч тухайн үеийн намын үзэл суртал, улс төрийн баримтлалын хүрээнд баригдаж гадаад харилцааны талаархи бодит үнэнийг бүрэн тусгаж чадаагүй нь мэдээж. Тийм дутагдлыг хожмын судалгаандаа засахыг оролдсон хэмээн тэмдэглэсэн байна.

*С.Дамдинсүрэн – ОУСХ-ийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор (Sc.D), профессор

Тэрээр МАХН-ын Төв Хорооны нарийн бичгийн даргын өндөр албыг хашиж байх үедээ ч өөрийн эрдэм судалгааны сонирхолдоо хөтлөгдөн Зөвлөлт Холбоот Улсад докторантурт суралцах хүсэлт гаргаж, 1972 оны 6-р сард НТХ-ны III бүгд хурлаар НТХ-ны нарийн бичгийн даргаас, мөн оны намар хуралдсан НТХ-ны бүгд хурлаар УТТ-ны орлогч гишүүнээс тус тус чөлөөлөгдөж байсан нь түүний судалгаа шинжилгээний ажилд хэр их татагдаж байсаныг илтгэн харуулна.

Ингээд тэрээр ЗХУКН-ын ТХ-ны дэргэдэх Марксизм-ленинизмийн институтын докторантурт 1972 оны намраас суралцаж, “МАХН-ын үйл ажиллагааны интернационализмын зарчим” сэдвээр докторын диссертаци бичиж, 1975 оны 6-р сард амжилттай хамгаалсан байна.

Б.Лхамсүрэн гуай МАХН-ын түүх, Монгол улсын тусгаар тогтнол, Гадаад бодлого, өөрчлөлт шиэнчлэлтийн онол арга зүйн тулгамдсан асуудлаар эрдэм шинжилгээний олон арван томоохон бүтээлүүд туурвисан нь манай улсын түүхийн шинжлэх ухааны хөгжилд тодорхой байраа эзэлсэн юм. Энд МАХН-ын товч түүхийн /1967, 1970, 1985/ гурван удаагийн хэвлэлийн ерөнхий редактороор ажиллаж, “МАХН-ын үйл ажиллагаанд интернационализмын зарчим хэрэгжсэн нь /1975/, “Хөдөлмөрчдийн эх оронч, интернационалч хүмүүжлийн асуудалд” /1978/ зэрэг судалгааны хэд хэдэн нэгэн сэдэвт зохиол, “Социалист интернационализм Олон улсын шинэ маягийн харилцааны онол практик” /1977 орос хэл дээр/, Монгол Хятадын харилцааны талаарх МАХН-ын интернационалч байр суурь /1984/ зэрэг хамтын бүтээлүүдэд зохиогчоор оролцсон байна.

Тухайн үед МАХН-ын түүхийг дээд сургуулиуд болон намын дугуйлангаар заавал судлах сурах бичгийн хэмжээнд боловсруулахыг үүрэг болгож байсан тул Намын товч түүх зохиох ажил үнэндээ хамгийн их хариуцлагатай нөр их ажил байсан билээ. Энэ тухай Б.Лхамсүрэн гуай дурсамждаа өгүүлэхдээ: “Товч түүхийн төслийг институтын эрдэм шинжилгээний ажилтан болон зарим дээд сургуулийн түүхч, эдийн засагчдын хүчээр анхны засварыг хийж редакцийн комиссын гишүүдээр хэлэлцүүлэн нягтлан боловсруулаад Улс төрийн товчоонд бүлэг бүлгээр танилцуулдаг байсан бөгөөд НТХ-ны нэгдүгээр нарийн бичгийн дарга Ю.Цэдэнбал үг өгүүлбэр бүрийг нарийвчлан уншиж тэмдэглэж өгдөг байсан ба түүний дараа ерөнхий редактор эцсийн засварыг гардан хийдэг байсан юм” гэжээ.

Ийнхүү МАХН-ын товч түүхийн 2 дахь хэвлэлийг 1970 онд, 3 дахь хэвлэлийг 1985 онд нийтлэсэн нь тухайн цаг үеийн хэрэгцээ шаардлагыг хангасан юм. Намын товч түүхийн 3 удаагийн хэвлэл нь түүний анхны төслийг гаргагчдаас аваад Намын түүхийн институтэд ажилласан Ц.Балхжав, Л.Бат-Очир, Ш.Бат-Очир, Б.Банзрагч, С.Дамдинсүрэн, Д.Даш, Ш.Жумдаан, С.Ичинноров, З.Лонжид Б.Лигдэн, А.Маамуу, Х.Магсаржав, А.Минис, Б.Монц, О.Пүрэв, Л.Санжаа, Б.Сумъяа, Д.Түмэнжаргал, Б.Цэдэн болон бусад эрдэмтэн судлаачдын хамтын бүтээл мөн хэмээн академич маань дурсах дуртай. Энэхүү хамтын бүтээлийг цаашид ямагт боловсронгуй болгон сайжруулах ёстой гэдэг санааг илэрхийлж Б.Лхамсүрэн гуай: “Бид тухайн үеийн намын улс төр, үзэл сурталын баримтлалын хүрээнд мэдлэг оюун хүч чадлаа дайчлан гаргасан бүтээлээ хэзээ ч бүрэн төгс болсон гэж үзэж байгаагүй юм. “МАХН-ын бүрэн бүтэн түүхийг зохиохын тул товч түүхэнд тусгагдаж чадаагүй буюу дутуу дулимаг, бүдэг ерөнхий болсон зүйлийг гүйцээж түүхэн баримт материалыг цаашид нягтлан судалж боловсруулах ажил шаардагдаж байгаа” гэж бүр 1964 онд нийгмийн ухааны багш нарын зөвлөлгөөн дээр тэмдэглэн хэлж байжээ. (“Нийгмийн ухааны хичээл заалтыг эрс өөрчлөн сайжруулая” 1964 он, 24-25 тал)

Академич Б.Лхамсүрэн гуайн судалгааны нэгэн том чиглэл Монгол улсын гадаад харилцааны асуудал хэмээн дээр нэгэнтээ дурьдсан билээ. Б.Лхамсүрэн гуай Монголын төрийн гадаад бодлогын уламжлал, шинэчлэлийн асуудлыг нарийн нягт судлан дүгнэж, өнөөгийн Монгол улсын гадаад бодлогын чиглэлийг тодорхойлоход өөрийн саналаа нэмэрлэсэн жинтэй эрдэмтэн билээ. Тэрээр “Монголын тусгаар тогтнол нь түүнийг үгүйсгэн цуцлах гэсэн өмнөд хөршийн эрмэлзэл, ил далд явууллагатай тулгарсаныг түүх гэрчилнэ. Монголын хувьд умард хөршийн байр суурь өөр байв. Хаант Орос улс ба ЗХУ-ын аль алин нь Монголыг эзлэн авах буюу өөртөө хавсарган нийлүүлэх хэмээгээгүй. Ар Монголыг хязгаарлагдмал эрхтэй бамбай улс байлгах гэсэн Оросын хаант Засгийн бодлогыг Зөвлөлт засаг өвлөн аваад тус орныг зөвлөлт маягаар шинэчлэх бас ч түүнтэй хил залгаа нутаг дэвсгэр рүү хувьсгал дэлгэрүүлэх түшиц газар болгох сонирхолтой байв. ЗХУ-ыг түшиглэсэн нь 70 жилийн турш Монгол улс оршин тогтносны гадаад шийдвэрлэх хүчин зүйл мөн байв” хэмээн XX зууны Монголын тусгаар тогтнол, гадаад нөхцөл байдалыг дүгнэжээ.

Харин ерээд оны Монголын гадаад харилцааны талаар хөндөхдөө: “Наяад оны сүүлчээс БНМАУ-ын гадаад байдалд үндсэн өөрчлөлт гарсан нь олон улсын тавцан дээр тус орон харьцангуй түгжигдмэл байдлаас ангижирч олон туйлт ертөнцтэй биеэ даан харилцах боломж олгожээ” хэмээн тэмдэглэжээ. /Б.Лхамсүрэн “Арван зургадугаар жаран мину” УБ., 2003, 118 дахь тал/

Академич Б.Лхамсүрэн гуай олон жилийн судалгааныхаа үр дүнд Монголын ирээдүйн гадаад бодлого, харилцааны чиглэлийг тодорхойлохдоо: Өнөөгийн нөхцөлд манай гадаад харилцаа, гадаад бодлогын аль алинд өөрчлөлт хийхийн утга учир нь үзэл суртал, улс төрийн ерөөсгөл баримтлалаас ангижирахад оршино. Манай орон өөрийн хөгжлийн түвшин, үндэсний өвөрмөц байдал, төв азийн соёл иргэншлийн онцлогийг хүн төрөлхтний нийгмийн дэвшлийн тэргүүний үзэл санаа эрхэм дээд эрмэлзлэлтэй цогцолбороор хослон тусгасан үзэл суртлын үндэсний хувилбартай баймааж нь орчин үеийн дэлхийн хөгжилтэй хөл нийлүүлэн урагшилж чадна гэж үзжээ. Тэрээр монголын хүн ард бол уугуул нутаг дэвсгэртээ олон үеийн турш аж төрж байгаа угсаа төрөл нэгтэй үндэстэн мөн. Манай ард түмэн түүхийн хүчтэй шуурга донсолгоонд оршин тогтнож үндэсний ахуй соёл оюуны хэв шинжээ олон зууны туршид хадгалж ирсний уг сурвалж нь үүнд оршино. Иймд гадаад орчин яаж өөрчлөгдсөн ч Монгол улс цаашид тусгаар тогтнон хөгжихийн шийдвэрлэх хүчин зүйл бол үндэснийхээ нэгдмэл цул байдлыг хадгалж түүний язгуур эрх ашиг, эв нэгдлийг дээдлэн хамгаалах явдал даруй мөн” хэмээн бичжээ. Энэ бол насаараа Монголын төрийн дотоод, гадаад бодлого, улс төрийн үйл ажиллагаанд оролцож, түүх, гадаад харилцааны чиглэлээр судалгаа хийсэн манай тулхтай эрдэмтний өнөө болон хойч үедээ өвлүүлж буй сургаал хэмээн үзүүштэй. Эрдэмтэн мэргэдийн энэ мэт бодит дүгнэлт, шинжлэх ухааны үндэслэлийг төрийн бодлого боловсруулахдаа ямагт харгалзан үзэж байх нь зохилтой болохыг тэмдэглэж байна.

Академич Б.Лхамсүрэн гуай нам, төрийн дээд удирдах алба хашиж, эрдэм шинжилгээ, судалгааны нөр их ажил хийхийн зэрэгцээ Монгол улсын шинжлэх ухаан, соёл, боловсролын тогтолцоог боловсронгуй болгон хөгжүүлэхэд бодитой үүрэг гүйцэтгэсэн чадварлаг зохион байгуулагч хүн юм. Ардын Их Хурлын тэргүүлэгчдийн 1961 оны 1-р сарын 5-ны зарлигаар Шинжлэх ухаан дээд боловсролын хороог өөрчилж Шинжлэх Ухааны Академийг байгуулж 9 академич, 19 сурвалжлагч гишүүнтэйгээр тогтоон, ерөнхийлөгчөөр

Б.Ширэндэвийг баталсан бөгөөд Б.Лхамсүрэн сурвалжлагч гишүүнээр сонгогджээ. ШУА байгуулахтай нэгэн зэрэг СНЗ-ийн дэргэд дээд ба тусгай мэргэжлийн дунд боловсролын хороо байгуулахаар шийдвэрлэж хорооны даргаар СНЗ-ийн орлогч дарга, Академийн сурвалжлагч гишүүн Б.Лхамсүрэнг хавсарган томилжээ.

Монгол Улсын дээд сургууль болон яамдын дэргэдэх дээд сургууль техникумудыг зохион байгуулалт, сургалт заах арга, эрдэм шинжилгээний ажлыг нэгдсэн удирдлагаар хангаж, боловсролын системийн шинэчлэх талаар багагүй зүйлийг Б.Лхамсүрэн даргатай уг хороо санаачлан, тодорхой асуудлуудаар амьдрал, нийгмийн хөгжлийн шаардлагыг тусгасан оновчтой шийдэл гаргаж байжээ.

Эрдэм шинжилгээний байгууллагын удирдах ажилд тавигдсан удаах томилолт нь 1981 оноос МАХН-ын Төв Хорооны дэргэдэх Намын түүхийн институтийн захиралын албан тушаал байв. Тэрбээр МАХН-ын онол эрдэм шинжилгээний энэ чухал төвийг намын түүхээ гүнзгийрүүлж судлахын зэрэгцээгээр намын өмнө тулгарсан онолын асуудлуудыг шинжлэх ухааны үндэслэлтэй боловсруулах чиглэлээр ажилдаг болгон үүргийг нь өргөтгөн өөрчлөн байгуулах, боловсон хүчнээр бэхжүүлэх, эрдэм шинжилгээний ажлын үр өгөөжийг дээшлүүлэхэд онцлон анхаарчээ. Энэ тухай тодорхой санал боловсруулан Намын Төв Хорооны 1-р нарийн бичгийн даргад тавьжээ. Үүний саналыг дэмжин 1981 оны НТХ-ны УТТ-ны 307-р тогтоолоор тус институтыг НТХ-ны дэргэдэх Нийгмийн ухааны институт болгон өөрчлөн байгуулж, зорилт, үйл ажиллагааны чиглэлийг шинэчлэн тодорхойлж түүний бүрэлдэхүүнд намын түүх, намын зохион байгуулалт, олон улсын коммунист хөдөлгөөн, социалист байгуулалтын гэсэн эрдэм шинжилгээний дөрвөн хэлтэс, Лениний музей, Намын Төв Архив, эрдэм шинжилгээний номын сан, орчуулга, хэвлэлийн болон социологийн судалгааны тасагтай байхаар тогтоож хэлтэс нэгжүүдийн ажил үүргийг тодорхойлон заажээ. Б.Лхамсүрэн захиралтай НУИ-ийн хамт олон намын тогтоол шийдвэр, баримт бичгүүдийн бүрэн эхээр нь эмхэтгэсэн эхний гурван боть, Д.Сүхбаатарын баримт бичгүүдийн долоо дахь хэвлэл болон түүний намтар үйл ажиллагаатай холбогдсон товхимолууд, намын Х их хурлын дэлгэрэнгүй тайлан зэрэг олон чухал сурвалжийг хэвлэн нийтэлж, зөвхөн түүхийн төдийгүй нам, улсын цаг үеийн тулгамдсан асуудлуудаар онол эрдэм шинжилгээнийхээ шинэ чиглэлийн дагуу олон талтай судалгааны бүтээлүүд туурвиж, эрдэм

шинжилгээний бага хурал, онолын семинар тогтмол зохиож намын онолын сэтгэлгээг хөгжүүлэх шинэ нөхцөл бүрдүүлсэн билээ.

Энэ үеэс НУИ гадаад орны онол эрдэм шинжилгээний байгууллагуудтай хоёр ба олон талын хамтын ажиллагаагаа идэвхжүүлж, олон улсын хамтын судалгааны тодорхой чиглэлийн группуудад өөрийн ажилтнуудын оролцоог мэдэгдэхүйц өргөтгөжээ. Тус институт цаашдаа улс төрийн шинэ сэтгэлгээ, ил тод байдал, олон ургальч үзлийн бүтээлч том төв болсон билээ.

Академич Б.Лхамсүрэн 1991 оноос Шинжлэх ухааны академийн Олон улс судлалын хүрээлэнд зөвлөгчөөр ажиллахдаа Монгол улсын тусгаар тогтнол, гадаад харилцааны асуудлыг гүнзгийрүүлэн судлаж, Монголын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрөх асуудалд холбогдох баримт материалуудын хураангуйг цуврал болгон гаргаж “Монголын гадаад орчин, төрийн тусгаар тогтнол” /1995 он/ хэмээх бүтээлийг хэвлүүлснээс гадна Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигийн дагуу боловсруулагдсан Монгол Улсын түүхийн таван боть зохиолын тавдугаар ботид “Дэлхийн хоёр системийн сөргөлдөөний нөхцөл дэх Монголын гадаад орчин, гадаад харилцаа” гэсэн томоохон бүлэг бичиж XX зууны монголын гадаад харилцааны сэдвээр эрдэм шинжилгээний сэтгүүл, эмхтгэлүүдэд судалгааны олон өгүүллээ нийтлүүлээд байна.

Монгол Улсын түүх, гадаад бодлого, гадаад харилцааны сэдвээр докторын зэрэг хамгаалсан Л.Жамсран, Ц.Батбаяр, О.Батсайхан, дэд эрдэмтний зэрэг хамгаалсан Д.Шүрхүү, Д.Лувсанбалдан нарын эрдэм шинжилгээний зөвлөгч, удирдагч байж, Шинжлэх ухааны академийн дэргэдэх Түүх, олон улс судлалаар Эрдмийн зэрэг цол олгох зөвлөлийн гишүүнээр ажиллаж байгаа нь Монголын төр, шинжлэх ухаанд шаардлагатай эрдэм боловсролтой шинэ эрдэмтэдийг төрүүлэхэд оруулж байгаа түүний хувь нэмэр хэмээн үзэж байна.

Шинжлэх ухааны бартаат их замыг туулж, монголын ард түмний оюуны санг арвижуулан баяжуулсан бууршгүй бүтээлээрээ 80 насны ойдоо золгож буй нэрт эрдэмтэн, шинжлэх ухааны доктор, академич Бадамын Лхамсүрэн гуайдаа эрүүл энх, урт удаан насалж эрдмийн их бүтээл нь түмэн олондоо улам улам түгэн дэлгэрч байхын өлзийтэй ерөөлийг өргөн дэвшүүлье.